



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЕНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

*дадл* Оны **04** сарын **08** өдөр


Дадлар *Ажлы*

Улаанбаатар хот

Г Дадлага сургуулилт зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, "Гамшигаас хамгаалах тухай" хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдааны 24 дүгээр тэмдэглэл, Шадар сайдын 2020 оны 33 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Ковид-19 халдварт цартахалтай тэмцэх бэлэн байдлын дадлага сургуулилт зохион байгуулахад Эрүүл мэндийн салбараас мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн"-ийг нэгдүгээр, дадлага сургуулилт зохион байгуулахад Эрүүл мэндийн салбараас авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж"-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай
2. Ковид-19 халдварт цартахалтай тэмцэх бэлэн байдлын дадлага сургуулилт зохион байгуулахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, эрүүл мэндийн салбарын бэлэн байдлыг ханггуулж оролцохыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.
3. Дадлага, сургуулилтын бэлтгэлийг хангаж, шаардлагатай санхүүжилтийн тооцоог хийж, байгууллагын батлагдсан төсвийн хүрээнд шийдвэрлэх, зайлшгүй шаардлагатай нэмэлт санхүүжилтийг Улсын онцгой комисс болон аймгийн онцгой комисстой хамтран шийдвэрлүүлэх, эмнэлгийн тусlamж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ үзүүлэх чадавхийг сайжруулж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Гамшигаас хамгаалах эрүүл мэндийн улсын штабын дарга /Я.Амаржаргал/-д даалгасугай.



Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн дараа дугаар тушаалын нэгдүүлээр хөвөрлийн  
166

**Ковид-19 халдварт цартахалтай тэмцэх бэлэн байдлын радиага  
сургуулилт зохион байгуулахад Эрүүл мэндийн салбараас мэргэжил арга зүйн  
дэмжлэг үзүүлэх ажлын хэсгийн бүрэлдэхүүн**

Ажлын хэсгийн ахлагч:

Штабын чиглүүлэгч.

Мэргэжил арга зүйн дэмжлэг  
үзүүлэх багийн гишүүд.

Я.Амаржаргал, Төрийн нарийн бичгийн дарга, Гамшигаас хамгаалах эрүүл мэндийн улсын штабын дарга,

Я.Буянжаргал, Эмнэлгийн тусlamжийн газрын дарга, Гамшигаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны эмнэлгийн тусlamж, үйлчилгээний асуудал хариуцсан ажилтан,

Н.Гэрэлт-Од, Эм, үйлдвэрлэл, технологийн газрын дарга, Гамшигаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны штабын мэргэжлийн ар тал, хангарт хариуцсан ажилтан  
Т.Бат-Эрдэнэ, Эрүүл мэндийн цахим мэдээллийн хэлтсийн дарга, Гамшигаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны штабын холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан

Б.Цогтбаатар, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Гамшигаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны штабын орлогч,

Р.Оюунханд, Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Гамшигаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны штабын холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан,  
Т.Энхзаяа, Нийгмийн эрүүл мэндийн газрын дарга, Гамшигаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны штабын сургалт, мэргэжлийн ангиуд, бэлтгэл, бэлэн байдал, хариуцсан ажилтан,

Д.Нарантуяа, Эдийн засаг, санхүүгийн хэлтсийн дарга, Гамшигаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны штабын мэргэжлийн ар тал, хангарт хариуцсан ажилтан,  
Д.Нарангэрэл, Олон нийттэй харилцах, тандалт, шуурхай удирдлагын хэлтсийн дарга, Гамшигаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны эрсдэлийн үеийн мэдээлэл, харилцаа холбоо хариуцсан ажилтан,

Г.Цэцэнсанаа, Эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга, Гамшигаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны штабын мэргэжлийн ар тал, хангарт хариуцсан ажилтан

Б.Янжмаа, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга  
Т.Бямбасүрэн, Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Гамшигаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны мэргэжлийн ар тал, хангарт хариуцсан ажилтан,

Д.Золзаяа, Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын хэлтсийн дарга

Г.Ганзориг, Хуулийн хэлтсийн дарга

Г.Ганхуяг, Эрүүл мэндийн даатгалын бодлогын хэлтсийн дарга

М.Оюунчимэг, Эмнэлгийн тусlamжийн газрын Төрөлжсөн мэргэжлийн тусlamж, уйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, Б.Нарантуяа, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан, Д.Нямхүү, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирал, Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны шинэ болон сэргэж байгаа халдварын асуудал хариуцсан ажилтан, Н.Цогбадрах, Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирал, Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны Зоонозын өвчиний асуудал хариуцсан ажилтан, Н.Эрдэнэбаяр, Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн ерөнхий захирал, Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны цус, цусан бүтээгдэхүүний хэрэглээ, хангамж хариуцсан ажилтан, Э.Галбадрах, Гэмтэл согог судлалын үндэсний төвийн ерөнхий захирал, Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны гэмтэл, ослын асуудал хариуцсан ажилтан, Д.Насанцэнгэл, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал, Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны сэтгэлзүйн асуудал хариуцсан ажилтан, Т.Мөнхсайхан, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн дарга, С.Энхболд, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн дарга, Ц.Төмөр-Очир, Улсын гуравдугаар төв эмнэлгийн дарга, Л.Төмөрбаатар, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, Б.Батцэнгэл, Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Ж.Од, Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газрын дарга Р.Отгонбаяр, АШУҮС-ийн эмнэлгийн захирал

Ажлын хэсгийн нарийн бичиг:

С.Алтанбагана, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусlamжийн газрын яаралтай, түргэн тусlamжийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны штабын нарийн бичгийн дарга. А.Долгорханд, Эрт сээрэмжлүүлэг, хариу арга хэмжээ, онцгой байдлын асуудал хариуцсан мэргэжилтэн, Гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны туслах.

—оOо—

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04 дүгээр сарын 05 нь дэдрийн дугаар тушаалын хөрдугаар хавсралт

**Ковид-19 халдварт цартахалтай тэмцэх, бэлэн байдлын дадлага  
сургуулилт зохион байгуулахад Эрүүл мэндийн салбарас авч хэрэгжүүлэх  
арга хэмжээний удирдамж**

**Үндэслэл.**

Монгол Улсад "КОВИД-19 халдварт цартахлаас урьдчилан сэргийлэх, цар тахалтай тэмцэх, эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг дээшлүүлэх, нэгдсэн удирдлага, зохицуулалт, хариу арга хэмжээний чиглэлийг боловсронгуй болгох чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудын чадавхийг нэмэгдүүлэх дадлага сургуулилт зохион байгуулах шаардлагатай байна.

**Зорилго.**

"КОВИД-19 халдварт цар тахлын үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ, хариу арга хэмжээ" сэдэвт дадлага сургуулилт зохион байгуулах,

**Зорилт.**

1. КОВИД-19 халдварт цар тахлын үеийн эрүүл мэндийн салбарын мэргэжлийн удирдлага зохион байгуулалт, салбар дундын хамтын ажиллагааг боловсронгуй болгох,
2. Халдварт өртөгсдөд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх бэлэн байдлын төлөвлөгөөг тодотгох сургуулилалт хийх,
3. Халдварт өртөгсдөд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх бэлтгэлийг хангаж, эмч эмнэлгийн мэргэжилтнийг сургаж дадлагажуулах,
4. Аливаа халдвартын цар тахлын хохирлыг багасгах хариу арга хэмжээг шуурхай авах дадалд суралцах,
5. Аливаа халдвартын цар тахлын үеийн эрсдлийн харилцаа холбоог удирдан зохион байгуулах дадалд суралцах,
6. Тайлгнант, мэдээллийн урсгалын нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгох.

**Хугацаа.**

Бэлтгэл хангах. 2020 оны 04 дүгээр сарын 24-ээс 05 дугаар сарын 05

Зохион байгуулах өдөр. 2020 оны 5 дугаар сарын 06-08

Тайлгнант. 2020 оны 5 дугаар сарын 08-15

**Зохион байгуулалтад оролцох байгууллага.** Эрүүл мэндийн яам,

Халдварт өвчин судлалын үндэсний төв, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газар, Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн бусад байгууллагууд

**Санхүүжүүлэгч байгууллага.** Улсын Онцгой комисс, Эрүүл мэндийн байгууллагын төсөв,

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа.**

№	Үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Хамтран байгууллага
1.	Хан-Уул дүүргийн "Эх, хүүхдийн эрүүл мэндийн төвд 100 ортой эмнэлэг ажиллуулах бэлэн байдлыг хангах, эмнэлэг дэлгэх арга хэмжээг зохион байгуулах	Нийслэлийн ЭМГ	ЭТГ, ЭҮТГ ЭЭЭХ, ХОХ
2.	Баянт-Ухаа спортын ордонд 300 ортой эрэмбэлэн ангилах, хөнгөн өвчтөн тусгаарлах төв дэлгэх объектыг эмнэлгийн зориулалтаар тоноглоход шаардлагатай эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжжөөр хангах, эмнэлэг дэлгэх үйл ажиллагааг зохион байгуулах	Нийслэлийн ЭМГ	ЭТГ, ЭҮТГ ЭЭЭХ, ХОХ

3.	Жаргалантын амны ОБЕГ-ын талбайд хээрийн эмнэлэгт ажиллах хүний нөөцийг бэлтгэх, хамтран ажиллах	ЦТГ	Э
4.	Дэлгэсэн эмнэлэгт ариутгал халдвартгуйжүүлэлтийн автомашин, тоног төхөөрөмж, бодис материалыаар хангах, үйл ажиллагааг зохион байгуулах	ЗӨСҮТ Нийслэлийн ЭМГ	Н
5.	ХӨСҮТөвийн томилгоот хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах, үйл ажиллагаанд оролцуулж, зохион байгуулалтыг хангуулах	ХӨСҮТ	ТЗУГ
6.	ЗӨСҮТөвийн томилгоот хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангуулах, үйл ажиллагаанд оролцуулж, зохион байгуулалтыг хангуулах	ЗӨСҮТ	ТЗУГ,
7.	Дадлага сургуулилтын үед ажиллах хүний нөөцийг бэлтгэх	ХӨСҮТ, ЗӨСҮТ, Нийслэлийн ЭМГ, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн ЭМГ	ТЗУГ,
8.	Дадлага сургуулилт зохион байгуулах эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж, зохион байгуулах	Лавлагaa төв, Төр, хувийн хувийн хэвшлийн бүх шатны ЭМБ	АЙМ НИЙСЛ ЭМ
9.	Мэдээллийн цахим санг бэлтгэх	БТГ ЭМЦМХХ	ЭТ
10.	Сургуулилтын үеийн бэлтгэлийн эмнэлзүйн заавар журмаар хангах	ХӨСҮТ, ЭСҮТ	Эмнэл зөвлө
11.	Халдвартын хяналт, сэргийлэлтийг зөвлөгөө өгч ажиллах /өреөний урсгал, хамгаалах хэрэгслийг ашиглах.../	ХӨСҮТ Тархварэйн зөвлөх баг	ЭТ ЭТҮЧ
12.	Олон нийттэй харьцах, эрсдлийн харилцаа холбооны чиглэлээр бэлтгэлийг хангаж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах	НЭМҮТ ХӨСҮТ, ЗӨСҮТ, Нийслэлийн ЭМГ, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн ЭМГ	НЭМ ОНХТ
13.	Дадлага, сургуулилтын бэлтгэлийг хангахад шаардагдах санхүүжилтийн тооцооллыг хийж, УОК-оор шийдвэрлүүлэх	ХӨСҮТ, ЗӨСҮТ, Нийслэлийн ЭМГ, Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн ЭМГ	ЭЗСХ ЭЗС
14.	Дадлага сургуулилтад ЭМЯ-асас оролцох багийг жигд хувцасаар хангах	ЭЗСХОГ	ЭЗС
15.	Хэвлэлийн баг томилох, дадлага сургуулилтын үеийн бичлэг хийх, баримтжуулах	НЭМГ -ОНХТШУХ НЭМҮТ	ЭЗС
16.	Дадлага, сургуулилтын үед эрүүл мэндийн салбарын бэлэн байдлын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан гаргах, архивлах	ЭТГ	

#### Хүрэх үр дүн:

- КОВИД-19 халдварт цар тахалтай тэмцэх бэлэн байдлын дадлага, сургуулилтыг зохиуулж, гамшгаас хамгаалах эрүүл мэндийн салбарын бэлэн байдал, хариу арга хэмжээн байдалд үнэлгээ өгсөн байна.
- Сургамжид үндэслэн цаашдын бэлэн байдлыг хангах төлөвлөлтөд тодотгол хийнэ.

--оОо--

